

ТҮВШИНШИРЭЭ СУМЫН 2023 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭ

Төрийн удирдлагын чиглэлээр:

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Н.Ганибал нар 2023 оны 09 дүгээр сарын 04-нд суманд ажиллаж Дэлгэрхаан багийн төвд хүндэтгэлийн гэрэл хөшөөний нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа. Багийн иргэдтэй уулзалт хийж, хөшөөний нээлтэд зориулан их нас, дааганы уралдаан зохион байгууллаа. 09 дүгээр сарын 05-нд Үнэгд, Өлзийт, Сэргэлэн, Өгөөмөр багийн иргэдтэй уулзалт зохион байгууллаа.

“Түвшинширээ хөгжил 2023-Алтан намар” үзэсгэлэн худалдаа 2023 оны 09 дүгээр сарын 24-нд зохион байгуулагдаж, үзэсгэлэн худалдаанд 28 иргэн аж ахуйн нэгж өөрсдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээрээ оролцож, шилмэл малын үзэсгэлэнд 11 өрхийн 28 мал оролцлоо.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалын хүндэтгэх өдрийг жил бүрийн 9 дүгээр сарын сарын 10-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлдэгтэй холбогдуулан, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ахлах ангийн суралцагчдын дунд “Хэлмэгдүүлэлтийн хар шуурга” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан зохион байгууллаа. Мөн улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн гэгээн дурсгалд зориулж ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад хэлмэгдэгсэдийн гэр бүлтэй хамтран сургалт зохион байгуулж, сургалтанд 150 гаруй хүүхэд хамрагдлаа.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 201 дүгээр тогтоолын дагуу “Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, үзүүлсэн тусламж дэмжлэг үзүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангаж ажилласан ажлын мэдээг аймгийн ГБХЗХГазарт хүргүүлсэн.

Түвшинширээ сумын дотуур байрны 87 хүүхдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан.

2023 оны 09 дүгээр сарын байдлаар Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авсан нийт 14 иргэдийн 121 365 596 төгрөг байна. Үүнээс хугацаа хэтэрсэн чанаргүй 6 зээлдэгчийн 65 804 591 төгрөгний үлдэгдэл байна.

Нэг зээлдэгчийн 20.664.800 төгрөгийн зээлийг хийлгэж хаасан ба хугацаа хэтэрсэн нэг зээлдэгчийн зээлийн төлөлтөөс 717.000 төгрөг тус тус хийлгэсэн байна. Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авсан иргэдийн мэдээллийг төв сервер рүү илгээж нэгтгэн тайлан илгээсэн.

Долоо хоног бүрийн Даваа гарагт хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн судалгааг программд тогтмол оруулж байна.

2023 оны 09 дүгээр сарын байдлаар сумын нийт суурин хүн ам 3454, өрх 996, хүн ам, өрхийн мэдээллийн цахим санд хяналт тавьж ажиллаж байна. Шинээр төрсөн 61, нас барсан 9 хүн бүртгэгдсэн.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

9 дүгээр сарын 8-нд шилэн дансанд байгууллагуудын сарын төсвийн гүйцэтгэл, орон нутгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл, ОНХСангийн төлөвлөгөө гүйцэтгэл, бусад мэдээ мэдээллийг шивж оруулсан.

Нийгмийн даатгалын НД 8, НД7 /ажиллагсдын цалин тооцооны хуудас/ тайлангууд мөн татварын ТТ 11, ТТ 12 буюу үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутган тооцсон татварын тайлангуудыг гарган интернетэд шивэн цахимаар илгээсэн.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Сумын төвлөрсөн халаалт дулаан, цэвэр усны шугам сүлжээ, тэдгээрийн барилга байгууламжийг шинээр байгуулах ажлыг “Сэтгэшгүй нэмэх” ХХК концессийн гэрээгээр хийхээр гэрээ байгуулж, уг ажлын хүрээнд энэ сард байгууламжийн газрыг хэмжиж, байгууламжийн ажлыг эхлүүлээд байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад батлагдсан тус сумын сургуулийн хүүхдийн 100 хүүхдийн хүчин чадалтай байрын шинэ барилгын ажлыг Сүхбаатар аймгийн "Түвшин мөнх" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд, нийт төсөвт өртөг нь 2,0 тэрбум төгрөг, үүнээс 2022 онд 160,0 сая төгрөг төсөвлөгдөж, 2023 оны төсөвт үлдэгдэл төсөв бүрэн батлагдаж шинэ дотуур байр 12 дугаар сард ашиглалтад орохоор төлөвлөгдөн, барилгын явц 50%-тай явагдаж байна.

Энэ онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудаас 9 дүгээр сард төсөвт байгууллагуудад ус цэвэршүүлэгч суурилуулах 20,0 сая төгрөгийн шууд худалдан авалтын ажил хийгдлээ.

2023 оны 09 дүгээр сарын 08-ний өдөр нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн болон хүүхдийн тоглоомын талбайн орчин тойрны хог хаягдлыг цэвэрлэж сумын төвийн нэгдсэн хогийн цэгийн талбайд шатааж устгасан. Нийт 2 тн хог түүж цэвэрлэж устгасан.

“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хаврын тарилтаар 4800 мод тарьсан ба усалгааг 7 хоног бүр хуваарийн дагуу хийж байна.

Цаг уурын нөлөөллийн байдлаас үүдэн сумын төвийн орчны зарим гуу, жалганд нуранга үүсэж осол аваар гарах нөхцөл бүрдээд байсан ба нуралт үүссэн гуу, жалгуудыг элс, хайргаар дүүргэж нөхөн сэргээлт хийсэн.

Аймгийн ХАА-н газраас ирүүлсэн ургац хураалтын мэдээг иргэн, айл өрх, аж ахуй нэгжийн нэрсээр гаргаж явуулав.

Үүнд: Сумын хэмжээнд 5 өрхийн 1га, 2 хоёр байгууллагын тариалсан 0.2 га, нийт программд шивэж оруулсан 1.2 га талбайгаас хураасан ургацын мэдээг хүргүүлсэн.

Ургац хураалтын мэдээгээр төмс-700 кг, лууван-170 кг, манжин- 100кг, сонгино - 180кг, өргөст хэмх -30кг, хүрэн манжин -50кг, чинжүү- 10кг, улаан лооль-5кг, тарвас- 40кг-ыг хурааж аваад байна.

Мөн иргэд аж ахуй нэгжүүдээс өвсний судалгаа авахад нийт 6000 боодол ногоон өвс өөрсдийн хэрэгцээнд болон зах зээлд борлуулахаар татан авч нөөцөлсөн байна.

Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд 5 багийн малчин өрх, мал бүхий өрхийн том малын хорогдол, төлийн мэдээг шивж оруулж байна. Одоогоор 4 багийн 729 өрхийн мэдээллийг шинэчлэн шивж, шивэлтийн ажил 84 %- тай байна.

Бог малын хээлтүүлэгчийн судалгаа гарган аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн. Сумын хэмжээнд хуц 1627, Ухна 1063 байна.

Мал угаалганд 5 багийн 70000 мал хамрагдсан. Үүнээс бод 600 бог 69400. Ажлын явц- 60,0%. Хээлтүүлэгч малыг бруцеллёзын шинжилгээнд 3 багийн 12 суурийн 1350 толгой малаас цус авч мал эмнэлги йн газарт хүргүүлээ.

Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулагдах Шинэ сэргэлт-Мал аж ахуй залуу малчдын үндэсний чуулганд оролцох залуу малчны мэдээллийг ХХААГ-т хүргүүлсэн.

Малчин өрхийн нүүдлийн судалгааг 10 малчин өрхөөс авч ХХААГ-т хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын 05 дугаар албан даалгавар гарч өвөлжилт хаваржилтийн бэлэн байдлыг хангуулах тухай төлөвлөгөө гарган ажиллаж байна. Өвөлжилт хаваржилтийн бэлэн байдлыг хангуулах арга хэмжээний тухай сумын Засаг даргын 01 дүгээр албан даалгавар гарч албан байгууллагын дарга эрхлэгч нарт хүргүүлэн албан даалгаврын дагуу байгууллагууд төлөвлөгөө гарган, төв суурин газрын өвөлжилтийн бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

Нохой устгалын ажлыг 9 дүгээр сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгуулж 78 нохой устгасан.

Сумын төвийн нэгдсэн хогийн цэгийг цэгцлэх ажил хуваарийн дагуу сар бүр тогтмол хийгдэж байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр: Нийгмийн халамж: 2023 оны 09-р сард 2021-2022 онд төсөл хөтөлбөрт хамрагдсан хөтөлбөрт хамрагдсан 13 иргэн хуваарийн дагуу 1,801500 мян. төгрөг төвлөрүүлэхээс 9 иргэн 1256500 мян. төгрөгийг төвлөрүүлсэн.

ХЭДСангаас олгогдох “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих”, “Иргэн, аж ахуй эрхлэгчид олгох санхүүгийн дэмжлэг” хөтөлбөрийг иргэдэд зарлаж сумын цахим хуудсаар 2023 оны 09-р сарын 29-ныг хүртэл хугацаанд зарлаж мэдээлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан аймгийн төвд болох няравын 14 хоногийн сургалтын зарыг иргэдэд мэдээлж 2 иргэний бүртгүүлж хамруулахаар болсон.

“Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т хамрагдах хүсэлтэй 1 малчин өрхийг сумын амьжиргаа дэмжих зөвлөлийн шийдвэрээр сонгон шалгаруулж, шалгарсан өрхийн холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллаж байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд хамрагдсан 7 иргэнд 395640 төгрөгийн мэдээллийг "Нөхөн олголтын" жагсаалтаар гарган бэлтгэн өгч нөхөн олгуулсан.

Сумын амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар нийгмийн халамжийн тэтгэвэрт 8 иргэнийг асаргааны тэтгэмжид шинээр болон дахин сунгалтад хамруулсан. Мөн олон улсын ахмадын баярын өдрийг тохиолдуулан сумын хэмжээнд нийт 307 ахмадын судалгааг гаргасан, уг судалгаанаас албан байгууллагын харъяалалтай 58, харъяалалгүй 249 ахмадын нэрийг сумын амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүдээр хэлэлцүүлэн баталсан, 249 ахмадын мэдээллийг нийгмийн халамжийн ехаламжийн программд бүртгэлээ.

09 дүгээр сард Нийгмийн халамжийн ehalamj системид нийгмийн халамжийн тэтгэвэрт сунгалт-3 иргэн, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсаны тэтгэмжид 9 иргэнд, Жирэмсэн эхийн тэтгэмжид 8 иргэнд, шинээр төрсөн 5, асаргааны тэтгэмжид 14 иргэн, ахмад-249 нийт 288 иргэний мэдээллийг бүртгэж тэтгэвэр тэтгэмжид бүрэн хамруулсан.

НИЙГМИЙН ДААТГАЛ: Эрүүл мэндийн даатгалд 13 иргэний 714600 төгрөг, ибаримтаар 22 хүний 1394200 төгрөгний орлого орсон. Сайн дурын даатгалд 41 хүний 4143150 төгрөгийн орлого төвлөрлөө. Энэ сарын байдлаар

тэтгэврийн санхүүжилт 175000000 төгрөг, тэтгэмжийн санхүүжилт 5000000 төгрөг байна. 9 дүгээр сарын тэтгэвэрт 2 банкаар дамжуулан 430 хүнд 238975415 сая төгрөгийн тэтгэвэр олгосон. Шинээр 4 иргэний тэтгэврийн материал хүлээн авч, тэтгэвэр тогтоогдсон. 4 хүнд 4602603 төгрөгийн жирэмсэн амаржсаны тэтгэмж олгосон.

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР: Ерөнхий боловсролын сургууль: Тус сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023-2024 оны хичээлийн шинэ жилийг 728 суралцагч, 71 багш ажилтантайгаар эхлүүлж байна. Суралцагчийн дотуур байранд 87 хүүхдийг хүлээн авч, үйл ажиллагааг эхлүүлээд байна.

Сургуулийн сурагчдын спортын амжилтыг хөгжүүлэх урамшуулах “СПОРТ НЭГ ӨДӨР” уриатай намрын спартакиадыг сургуулийн багш нар биеийн тамирын багштай хамтран амжилттай зохион байгууллаа.

“СУРГУУЛЬД БЭЛТГЭГДСЭН БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ” судалгаанд энэ хичээлийн жилд нэгдүгээр ангийн 3 бүлгийн 79 суралцагч хамрагдах ба үнэлгээг бага боловсролын бүлгийн багш нар болон дуу хөгжим, биеийн тамирын багш нар удирдан зохион байгуулж байна.

Хүүхдийн цэцэрлэг: Түвшинширээ сумын хүүхдийн цэцэрлэг нь 2023-2024 оны хичээлийн жилд 235 хүүхдийг өдрийн бүлэгт, 63 хүүхэд хувилбарт сургалтад хамруулаад байна. Хичээлийн шинэ жилийн “Цэцэрлэг минь сайн байна уу?” нээлтийн үйл ажиллагааг сумын соёлын төвд зохион байгууллаа.

Цэцэрлэгт хамрагдах 2-5 настай 235 хүүхдийг сумын Эүүл мэндийн төвтэй хамтран урьдчилан сэргийлэх үзлэг, цагаан хорхойн шинжилгээнд 100% бүрэн хамруулсан.

Ажлын байран дахь сургалт 2 удаа зохион байгуулагдаж, 18 багш ажилтан хамрагдсан байна.

Цэцэрлэгийн нийт эцэг эх, асран хамгаалагчдын уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулж нийт 87 эцэг эх хамрагдсан. Үүнд цэцэрлэгийн зорилго зорилт, эцэг эхийн эрх үүрэг оролцоог танилцуулж тэдний санаа бодлыг сонсож цаашид хийж хэрэгжүүлэх төлөвлөгөөндөө тусган ажиллалаа. Мөн цэцэрлэгийн эцэг эхийн зөвлөлийг шинэчлэн байгуулж идэвхжүүллээ.

“Алтан намар” спортын наадмыг хүүхдийн дунд зохион байгуулж 8 бүлгийн 235 хүүхдийг хамрууллаа.

Багш, Эцэг эхийн хамтын ажиллагааг сайжруулах идэвхжүүлэх зорилгоор гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгууллаа.

Ажлын хэсгүүдийг шинэчлэн байгуулж цэцэрлэгийн орчин болон бүлгүүдэд эрсдлийн үнэлгээг хийлээ. Дотоод хяналтын баг 1 удаагийн хяналт шалгалтыг хийж гарсан зөрчил дутагдлыг дор бүр нь арилгуулж ажиллаа.

Ёс зүйн баг, Хүүхэд хамгааллын баг шинээр ажилд орсон багш ажилтанд ёс зүйн дүрэм, хүүхэд хамгааллын бодлогыг танилцуулж гарын үсэг зурж баталгаажууллаа.

СОЁЛЫН ЧИГЛЭЛЭЭР: 09 дүгээр сарын 07-10-ны өдрүүдэд байгууллага нь сумын орон нутаг судлах танхимын үзмэр эд өлгийн зүйлсийг бүртгэн баримтжуулах, үнэлгээ тогтоох, үзмэрийн хадгалалт хамгаалалтыг сайжруулахад анхаарах зөвлөмж арга зүйгээр хангуулан дэмжлэг авах зорилгоор аймгийн Угсаатны зүй музейн мэргэжилтэнгүүдтэй хамтран ажиллалаа. Мөн уг хугацаанд нутгийн уугуул, уран сийлбэрч Л.Монхоорой агсны хүч хөдөлмөр, оюун санаа, ур ухаан, авьяас билиг сэтгэл зүрхээ шингээн урласан бүтээлийн үзэсгэлэнг төрөлх нутгийнх нь Соёлын төвийн ОРОН НУТАГ СУДЛАХ МУЗЕЙ-д дэглэн нутгийн ард иргэд, хүүхэд багачуудын мэлмий оюуныг баясгасан үйл ажиллагааг аймгийн Угсаатны зүйн музейтай хамтран зохион байгуулж, 1287 үзэгч үзэж сонирхсон байна.

09 дүгээр сарын 10-нд Соёл урлагийн газрын даргаар ахлуулсан зөвлөн туслах багийн мэргэжилтнүүд “Монгол Улсын Соёлын тухай хууль”-д тавигдах ерөнхий шаардлага, хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн үр дүнг нэмэгдүүлэх, мөн бусад хууль, ажлын чиглэлээр байгууллагын албан хаагч нарт сургалт мэдээлэл зохион байгуулж, зөвлөмж аргазүйгээр хангаж ажиллалаа.

Монголын соёлын ажилтны өдрийг тохиолдуулан 09 дүгээр сарын 10-нд сумын соёлын биет болон биет бус өвийг өвлөн уламжлагч нарын анхдугаар зөвлөгөөнийг зохион байгууллаа. Сумын хэмжээнд 45 өв өвлөн уламжлагч, суралцагч, биет өвийн 10 болон, баримтат өвийн 6 эзэмшигч бүртгэлтэй бөгөөд түүх соёлын үл хөдлөх дурсгалын 14 гэрээт хамгаалагч байдаг. Тэдгээрээс 65 нь зөвлөгөөнд оролцсон байна. Монгол Улсын биет бус соёлын өвийн төлөөллийн үндэсний бүртгэлд долоон ай, 279 өв бүртгэлтэй байдаг аж. Тус сумын хувьд долоон айд хамаарах соёлын биет бус өвөөр 17 төлөөллийн бүртгэлтэй байна. Энэ удаагийн зөвлөгөөнөөр соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч нарт СУГазрын дарга Б. Золхүү "Монголчуудын нэгдмэл үнэт зүйл - Үндэсний тусгаар тогтнол", СУГазрын Соёлын өв хариуцсан мэргэжилтэн Г. Болортуяа "Соёлын өвийг хамгаалахад иргэн бидний оролцоо хамгаалалт", Сүхбаатар аймгийн Угсаатны зүйн музейн БМСанч О.Гандиймаа "Соёлын өвийг хамгаалах тухай" хуулиар сургалт мэдээлэл хүргэлээ. Зөвлөгөөнд ардын авьяастнууд болон соёлын биет бус өв өвлөн уламжлагчид ая дуугаа өргөсөн бол соёлын бүтээлч үйлдвэр гар урлалын бүтээлийн үзэсгэлэн дэлгэгдсэн байна. Зөвлөгөөний үеэр соёлын өвлөн

уламжлагчдад сумын ИТХ-ын хүндэт өргөмжлөл, мөн Соёлын төвийн дарга талархал гарын бэлэг гардуулж хүндэтгэл үзүүлсэн байна.

Соёлын төвийн дэргэдэх нийтийн номын сан нь 2023 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа хүргэн ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 25 дугаар зарлигийн жил бүрийн 09 дүгээр сарын 01-ний өдрийн ЭХ ХЭЛНИЙ ӨДӨР, “НОМЫН БАЯР 2023” арга хэмжээний хүрээнд Монгол хэлний хэм хэмжээг дагаж мөрдөх, хос бичигтэн болох, эх хэлээрээ бахархах өдрийг иргэд, хүүхэд багачуудад сурталчлан хүргэх зорилгоор шинэ номын үзэсгэлэн, дугуйланд суралцагч багш, сурагчдын монгол бичвэрийн материал зэргийг дэлгэн үзэсгэлэнг амжилттай зохион байгууллаа. Үзэсгэлэнд Сумын иргэд, ЕБС-ийн хүүхэд багачууд гэсэн нийт 700 гаруй хүн хамрагдлаа.

09 дүгээр сарын 04-05-ны өдрүүдээр Дэлгэрхаан, Үнэгд, Өлзийт зэрэг багуудад зөөврийн номын сангийн үйлчилгээг үзүүллээ. Мөн Эх хэлний өдөрт зориулсан “АХА” тэмцээнийг Дэлгэрхаан багийн иргэдийн дунд амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд 35 иргэд оролцлоо.

Мөн 09 дүгээр сарын 8-10-ны өдрүүдэд Номын сангийн фондонд дах МУСоёлын Гавьяат Зүтгэлтэн Г.Мэнд-Ооёо, Д.Маам нарын уран бүтээл, яруу найраг номын үзэсгэлэнг дэлгэн үзэгч олонд сонирхууллаа.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР: Амбулаторийн нийт үзлэг 346, алсын дуудлага 7, гэрийн дуудлага 11, хэвтэн эмчлүүлэгч 28. Халдвартай бүсэд хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөн байхгүй.

2023 оныг "Хүүхдийн хөгжил хамгааллыг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан аймгийн Засаг даргын А/478 тоот захирамжийн дагуу хүүхдийн шүдний өвчлөлийг илрүүлэх, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээний хүрээнд Сүхбаатар аймгийн "Аман хужир" шүдний эмнэлэг 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн ЕБС-ийн үзлэг эмчилгээ хийж, урьдчилан сэргийлэх үзлэгт 636 хүүхэд үзлэгт хамруулж, 152 хүүхдийн амны хөндийг эмчилж, 68 хүүхдийн шүдийг бүрэн эрүүлжүүлсэн. Үзлэгт хамрагдсан хүүхдийн нийт суралцагчдын тоонд эзлэх хувь-88,9%

Хөдөөгийн алслагдсан багийн иргэдэд нарийн мэргэжлийн эмчийн тусламж үйлчилгээ үзүүлэх явуулын амбулаторийн үзлэг 9 дүгээр сарын 22, 23-ний өдрүүдэд суманд ажиллаж, 7 төрлөөр давхардсан тоогоор 1601 иргэнд эрүүл мэндийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг үйлчилгээ хүргэлээ. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгээр 247 хүн сүрьеэгийн үзлэг шинжилгээнд хамрагдсан.

Нялхас болон бага насны хүүхдийн хооллолт сэдэвт сургалтыг Нийгмийн эрүүл мэндийн сувилагч ЭМТ-ийн ажилчид болон иргэдэд зохион байгууллаа.

Сар бүр хийгддэг товлолын вакциныг 45 хүүхдэд хийсэн.

6 настай хүүхдийн эрт илрүүлэг үзлэгт 74 хүүхэд хамрагдсан.

Тухайн сард лабораторийн хийсэн шинжилгээ үйлчилгээ: сахар – 70, шээсний ерөнхий шинжилгээ- 16, цагаан хорхойн өндөг илрүүлэх шинжилгээ – 360, Ковид-8, БЗХӨ-798, холестрин-70, хеликобактерын шинжилгээнд-70 хүн тус тус хамруулаад байна.

Тайлан нэгтгэсэн:

ХЭЗХМэргэжилтэн

Ш.Дүүрэнбилэг

Хянасан:

Тамгын газрын дарга

Ц.Ренчинмядаг